

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНД
ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ**

Д/ д	Зорилт	Хувь (%)	Биелэлт
1	2	3	4
1	Ажлын байрны тодорхойлолтыг ажлын байр тус бүрээр шинэчлэн батлуулах	100%	Тухайн онд ажлын байрны бүтэц, зохион байгуулалт, холбогдох өөрчлөлттэй холбоотойгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх, дахин боловсруулах ажил хийгдсэн ба 2026 онд мөн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор нэмж өөрчлөх ажил үргэлжлэн хийгдэж байна.
2	Хүний нөөцийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	90%	Компанийн хүний нөөцийн бодлогын баримт бичгийг холбогдох баримт бичиг хууль дүрэм журамтай нийцүүлэн шинэчлэлт хийж төслийг холбогдох удирдлагуудад танилцуулж санал авах ажил хийгдсэн ба танилцуулагдаж ирүүлсэн саналыг нэгтгэн тусгаж дахин боловсруулах шатанд ажил хийгдэн ажиллаж байна.
3	Компанийн бүтэц орон тоог оновчтой зохион байгуулах	100%	Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/83 тоот тушаалаар “Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам” шинэчлэн батлагдсантай холбоотойгоор ирэх онд тухайн журмын хэрэгжилтийг хангаж ажиллах нь цаашдаа хүний нөөцийн төлөвлөлт, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй үр нөлөөтэй явуулахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.
4	Холбогдох журмуудад өөрчлөлт оруулах, шинэчлэх	100%	2025 онд компанийн хэмжээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулсан 5 дүрэм, 66 журам, нийт 71 дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна. Тайланд онд 1 дүрэм, 5 журамд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан байна.
5	Хэлтсийн албан хаагч тус бүр өөрсдийн гүйцэтгэж буй ажил мэргэжлийн холбоотой сургалтад хамрагдаж, өөрсдийгөө хөгжүүлэх	100%	ЭХС-ын хүний нөөцийн мэргэжилтнүүдийн сургалтад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Нямсүрэн, Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооны Ахисан түвшний хөдөлмөрийн эрүүл ахуйн сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд Бага эмч Э.Алтантуул, АЗ сургалтад 2025.10.24,27

			өдрүүдэд Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Нямсүрэн, Бага эмч Э.Алтантуул нар тус тус хамрагдаж, АЗ-ын сертификат авсан.
6	Шинээр ашиглалтад орох хурлын заал, цайны газрын тохижилт, сургалтыг кабинетийг шинээр тохижуулах ашиглалтыг хариуцах,	80%	2025 онд Шинээр ашиглалтад орох хурлын заал, цайны газрын тохижилт, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг гүйцэтгэв. 2026 онд сургалтыг кабинетыг шинээр тохижуулах засварын ажлыг компанийн дотоод нөөц боломжоор засварлах, сайжруулах талаар судалж байна. 2025 онд архивын өрөөг өргөтгөн засвар үйлчилгээг хийлгэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тохижуулсан байна.
7	Нийт ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах	100%	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээг “Итгэл” эрүүл мэндийн төвтэй 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 05 -ны өдрүүдэд зохион байгуулж, 256 ажилтан албан хаагч хамрагдлаа. Үүнээс шаардлагатай ажилтан албан хаагчдын харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүд рүү явуулж шаардлагатай эмчилгээг хийлгүүлсэн
8	Компанийн хэмжээнд явагдаж буй сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, чанаржуулах тал дээр анхаарал хандуулан ажиллах	100%	Сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулах байгууллага, багшийг сонгон шалгаруулах, хариуцлагатай, үр дүнтэй зохион байгуулах тал дээр анхаарч ажиллалаа. Нийт ажилтны ХАБЭА-н сургалтыг мэргэжлийн байгууллагаар жилд 2 удаа, ИТА нарт зориулсан ХАБЭА-н сургалт, гамшгаас хамгаалах дадлага (тактик) Онгой байдлын сургалт арга зүйн төвд зохион байгуулж ажилласан давуу талтай байна. Сургалтын үйл ажиллагааны чанаржуулах зорилгоор Сургалтын журам батлуулахаар ажиллаж байна. Журмаар Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийг баталгаажуулснаар ажилтнуудыг мэдээллээр хангах, мэдээ мэдээллийг оновчтой арга хэлбэрүүдийг сонгож хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр батлагдсанаар сургалтын үр дүнг сайжруулна. Дээрх журам батлагдаагүй байгаа тул “Шинэ ажилтны сургалтын хөтөлбөр”-ийн батлуулан ажиллаж байна. Дээрх хөтөлбөрийн дагуу 2025 онд шинээр ажилд орсон 21 ажилтанд 2025 оны 02 дугаар сарын 07, 09 дүгээр сарын 23-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан байна.

			ИТА-ууд болон Мэргэшсэн, зөвлөх инженерүүдийн дотоод сургалтын хуваарийг батлуулж, хэвшүүлсэн ба ИТА-уудын дотоод сургалтын хуваариар 14 ИТА 11 цагийн хичээлийг 313 ажилтанд, Мэргэшсэн болон зөвлөх инженерүүдийн дотоод сургалтын хуваариар 4 ИТА 6 цагийн хичээлийг 101 ажилтанд сургалт оров.
9	Баяр ёслол, олон нийт, үйл ажиллагааг төсөвт төлөвлөгөөний дагуу зохион байгуулах,	100%	2025 онд Сар шинийн золголт, Байгууллагын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээн, Ахмадуудын дундах спортын тэмцээн, Туг мандуулах ёслол, Эрчим хүчний ажилтны өдрийн болон Ажил мэргэжлийн аварга шалгаруулах баярын хурлыг тус тус зохион байгуулсан байна. 2025 оны төлөвлөгөөт урлаг, спорт, баяр, ёслолын арга хэмжээнүүдийн гүйцэтгэл нь 16,260 мянган төгрөг байна. Дээрх зардлыг үйл ажиллагааны бус орлогоос тооцон гаргасан байна.


2025 онд дэвшүүлсэн зорилтууд 96,6% биелсэн.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2.1. Хүний нөөц, бүтэц зохион байгуулалт

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор компанийн бүтэц орон тоонд өөрчлөлт оруулан 2 менежер, 1 алба, 1 төслийн нэгж, 4 хэлтэс, 4 цехтэй нийт ажилтны орон тоо 326 байхаар сүүлийн байдлаар батлагдсан.

“ДЦС-2” ТӨХК-ийн бүтэц зохион байгуулалт



2025 оны хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгаа

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан 2025 оны компанийн төлөвлөгдсөн бүтэц орон тоо 326 хүнтэй ажиллахаас 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 273 хүн буюу 83,7 хувьтай ажилласан байна. Үүнд: Удирдлага-2


- ИТА-54
- Албан хаагч-16
- Ажилтан-201

- Хэвийн нөхцөлд-32 ажилтан
- Хэвийн бус нөхцөлд нийт- 241 ажилтан Үүнээс:

хүнд-163 халуун-70 хортой-8
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Бүтэц, орон тооны төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт

№	Алба, хэлтэс, цех	2023 он		2024 он		2025 он	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Удирдлага	2	2	2	2	2	2
2	ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор	-	-	1	1	1	1
3	Менежер	-	-	2	0	2	0
4	Төслийн нэгж	-	-	13	1	15	0
5	Техникийн бодлого төлөвлөлт, шуурхай ажиллагааны алба	12	9	12	9	10	9
6	Захиргаа удирдагын хэлтэс	8	6	8	7	8	6
7	Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтэс	10	8	10	9	10	8
8	Хяналт техник аюулгүй ажиллагааны хэлтэс	5	5	4	4	4	4
9	Аж ахуйн хэлтэс	20	17	20	17	20	17
10	Түлш дамжуулах цех	50	44	50	48	50	47
11	Зуухан цех	90	75	90	77	90	75
12	Турбин-Хими цех	61	55	61	59	61	57
13	Цахилгаан, дулааны хянах хэмжүүр автоматикийн цех	53	48	53	47	53	47
Нийт		311	269	326	281	326	273



Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

✓ Хөдөлмөрийн гэрээ байгуулсан нийт- 27 ажилтан


Үүнээс:-	Хүүхэд асрах чөлөөнөөс	-6 ажилтан
	Шинэ ажилтан	-20 ажилтан
	Цэргээс халагдаж ирсэн	-1 ажилтан

✓ Хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан нийт – 35 ажилтан

Үүнээс:	Ажил олгогчийн санаачилгаар -	-4 ажилтан
	- Өндөр насны тэтгэвэрт	-10 ажилтан
	- Өөрийн хүсэлтээр	-19 ажилтан
	- Гэрээний хугацаа дууссан	-2 ажилтан


✓ Алба, хэлтэс, цех болон нэгж дотроо шилжин ажилласан - 17 ажилтан

/Ажлаас гарсан нийт 35 ажилтны 10 нь тухайн тайлант онд ажилд шинээр орсон ажилтнууд байна./



Ажилтнуудын боловсролын байдал Эрчим хүчний салбарын их дээд сургуулийг эрчим хүчний мэргэжлээр төгссөн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй 64 ажилтан, бусад их дээд сургуулийг цахилгаан, дулааны мэргэжлээр төгссөн ажилтан 21, бусад мэргэжлийн ажилтан 44 байна. Тус байгууллагад докторант 1, магистрын цол зэрэгтэй 14 ажилтан байна.

Харьцуулалтаас харахад жилээс жилд дээд боловсролтой ажилтнуудын тоо буурч байна.



ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС



Мэргэшлийн зэрэг


2025 оны байдлаар зөвлөх инженер 2, мэргэшсэн инженер 5, мэргэшсэн нягтлан бодогч 2 байна.

Насны ангилал



Нийт 273 ажилтныг насны ангиллаар нь задалж харуулвал:

- 18-35 насны - 127 ажилтан
- 36-45 насны - 93 ажилтан
- 46-55 насны - 51 ажилтан
- 55-аас дээш насны – 2 ажилтан тус тус ажиллаж байна.



2025 оны гүйцэтгэлээр компанийн

-Хамгийн залуу ажилтан-18 настай

-Хамгийн өндөр настай ажилтан нь-61 настай байна.

Хүйсийн харьцаа




Компанийн нийт 273 ажилтны 71,7 хувь нь буюу 196 нь эрэгтэй ажилтан, 28,3 хувь буюу 77 нь эмэгтэй ажилтан байна. Нийт ажилтны дийлэнх хувийг эрэгтэй ажилтан эзэлж байгаа нь салбар болоод үйлдвэрийн ажил мэргэжлийн онцлогоос хамааралтай.

Ажилласан жил

Нэгжийн нэр	Станцад ажилласан жил								Нийт
	0-5	6-10	11-15	16-20	21-25	26-30	31-35	36+	
Удирдлага	2	-	-	-	-	-	-	-	2
ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор	-	-	-	1	-	-	-	-	1
Менежер	-	-	-	-	-	-	-	-	0
Төслийн нэгж	-	-	-	-	-	-	-	-	0
ТБА	1	1	6	1	-	-	-	-	9
ЗУХ	4	-	2	-	-	-	-	-	6
СБХ	5	-	2	1	-	-	-	-	8
ХХ	1	1	-	-	-	-	2	-	4
ААХ	7	4	3	2	-	-	1	-	17
ТДЦ	16	5	12	9	3	-	2	-	47
ЗЦ	36	16	7	10	4	1	1	-	75
ТХЦ	20	15	4	9	2	6	1	-	57
ЦДХХАЦ	21	9	5	7	3	2	-	-	47
Нийт	113	51	41	40	12	9	7	-	273

Компанид нийт ажилтнуудын ажилласан жилийн судалгаанаас харахад 0-5 жил ажиллаж буй залуу ажилтнууд 113 ажилтан буюу 41,3% эзэлж байна.




Удаан жилийн нэмэгдэл



Удаан жилийн нэмэгдлийг 10-40 хүртэл хувиар нийт 242 ажилтан авч байна. Үүнээс 158 ажилтан 30-40 хувийн нэмэгдэл авч байна. Энэ нь нийт ажилтны 57 хувь, удаан жилийн нэмэгдэл авч байгаа ажилтны 65 хувийг эзэлж байна. Үүнийг графикаар харуулав..


Удаан жилийн нэмэгдэл



Ажилтнуудын зэрэг дүүргэлт

Нэгжийн нэр	II зэрэг		III зэрэг		IV зэрэг		V зэрэг		VI зэрэг	
	төл	гүй	төл	гүй	төл	гүй	төл	гүй	төл	гүй
2023 он	7	6	69	73	67	55	47	21	20	12
2024 он	7	6	69	81	67	66	47	17	20	9
2025 он	7	6	69	64	67	56	47	20	20	8

Ажилтнуудын зэрэг дүүргэлт




Сахилгын шийтгэл

2025 онд ёс зүйн болон сахилгын зөрчил гаргаж гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэлийн арга хэмжээ авагдсан нийт 5 ажилтан байна. Үүнд:

- ❖ Сарын үр дүнгийн шагналт цалин хасах – 3
- ❖ Хаалттай сануулах – 1
- ❖ Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах-1

Ахмад настан, групптэй хүмүүсийн мэдээлэл



Групптэй хүмүүсийн мэдээлэл

Компанийн хэмжээнд мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, групп тогтоолгосон 8 хүн байна. Тайлант онд группээс 2 хүн өндөр настанд шилжсэн байна. 2025 оны байдлаар Компанийн хэмжээнд өрх толгойлсон эцэг, эх 12 байна.

Шагналын талаарх мэдээлэл

2023 оноос хойш шагнагдсан шагналын судалгаа

№	Шагналын нэр		Ажилтан			Өндөр настан			Нийт
			2023	2024	2025	2023	2024	2025	
1	Төрийн шагнал	ХГУТО	1						1
2		Алтан гадас	2	2	3	2	1		10
3		Хөдөлмөрийн хүндэт	5	1	2				8
4	ЭХЯ-ны шагнал	ЭХТА	2	7	7	4	2	1	23
5		Жуух бичиг	4	10	9				23
6	ЭХС-ын шилдэг ажилтан				1				1
7	Бусад салбарын тэргүүн, жуух		2						2
8	Онц тээвэрчин			1					1
9	МЗХ-ны тэргүүний залуу		9	8	8				25
Нийт			25	29	30	6	3	1	94

“Эрчим хүчний тэргүүний ажилтан” цол тэмдэг

Компанийн хэмжээнд 2025 оны байдлаар 273 ажилтнаас 67 ажилтан, 210 өндөр наснаас 191 өндөр настан тус тус Эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдэгтэй байна



Цаг ашиглалт

2025 оны ажлаас хоцорсон буюу тарахдаа эрт гарсан
бүртгэлийн суутгалын дүн


№	Нэгжийн нэр	Сар											НИЙТ
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X, XI	XII	
1	ТДЦ	127,900	208,600	198,200	146,000	258,600	170,400	93,400	108,800	156,200	88,600	87,400	2,225,400
2	ЗЦ	162,200	210,800	257,600	155,200	268,400	192,400	246,800	209,000	194,400	218,400	110,200	1,644,100
3	ТХЦ	53,800	92,000	150,000	32,200	209,600	56,600	69,000	66,800	69,600	71,400	31,200	902,200
4	ЦДХХАЦ	130,800	117,200	121,000	109,200	140,600	140,000	113,600	154,400	122,100	119,200	104,600	1,372,700
5	ЗУХ	19,400	5600	10,200	1000	28,000	26,600	18,200	82,400	13,800	50,800	16,800	272,800
6	ТБА	24,600	37,000	62,100	62,000	42,000	36,400	46,400	43,400	12,200	42,100	11,200	419,400
7	ХХ	5000	1800	4600	6800	2000	3600	1400	10,000	9600	12,000	14,800	71,600
8	СБХ	43,400	65,200	64,600	22,400	18,600	45,000	21,200	66,600	32,400	67,200	18,400	465,000
9	ААХ	60,400	36,200	99,400	56,800	112,400	63,000	48,400	123,400	48,800	171,200	131,600	951,600
Нийт дүн		627,500	774,400	967,700	591,600	1,080,200	734,000	658,400	864,800	659,100	840,900	526,200	8,324,800

ЭРҮҮЛ МЭНД

Ажлын байран дээрх үзлэг


№	Үзлэг үйлчилгээний төрөл	Хамрагдсан ажилтны тоо
1	Давтан үзлэг	683
2	Шинэ ажилд орсон	33
3	Сахар хяналт	2
4	Дусал тариа	175
5	Бариа засал эмчилгээ	23
6	Судас тариа	215
7	Арьсан доорхи тариа	5
8	Булчин тариа	192
9	Нүд цэвэрлэсэн	14
10	Физик эмчилгээ	354
11	Жор бичсэн	12
12	Эм олгосон	324
13	Лист бүртгэсэн	111
14	Боолт хийсэн	67
Нийт		2210

Хамрагдсан ажилтны тоо





2025 онд ХЧТАлдсан ажилтны тоо 111 байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.



Эрүүл мэндийн үзлэг

Эрүүл мэндийн үзлэгт “Итгэл эрүүл мэндийн төв” эмнэлэг гүйцэтгэгчээр шалгарч Т-25-76 гэрээг байгуулан нийт ажилтнуудыг 2025 оны эрүүл мэндийн үзлэгийг 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Үзлэг, шинжилгээнд нийт 256 ажилтан, албан хаагчид хамрагдсан байна. Эрүүл мэндийн үзлэгийн дараах байдлаар зохион байгуулсан байна.



СУРГАЛТ

2025 оны төсөвт төлөвлөгөөт сургалтууд сая.төг/

Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
	Зардал /сая төг/	Хүний тоо	Зардал /сая төг/	Хүний тоо	Зардал /сая төг/	Хүний тоо
Төлөвлөгөө	49.5	1157	59	1151	79.9	1225
Гүйцэтгэл	26.71	403	53.4	703	57.5	1081
Хувь %	54	34.8	90.5	61.1	72.0	88.2



Мөн төсөвт өртөггүй гадны байгууллагын 38.5 цагийн сургалтад 183 ажилтан хамрагдсан байна.

Мэргэжлийн шалгалтын комиссын талаар

Энэ онд Мэргэжлийн шалгалтын комисс нь 31 ажилтнаас шалгалт авсан байна. Үүнд:

- ✓ Мэргэжлийн зэрэг авах шалгалтанд –22 ажилтан (III зэрэг 17, IV зэрэг 3, V зэрэг 2)
- ✓ Мэргэжлийн зэрэг ахиулах –2 ажилтан (IV зэрэг 1, V зэрэг 1)
- ✓ Ажлын байр өөрчлөгдсөн (засварын хэсгээс ашиглалтын хэсэг рүү шилжсэн)- 3 ажилтан (III зэрэг 3)
- ✓ Хүүхэд асрах чөлөөнөөс орсон- 4 ажилтан (IV зэрэг 2, V буюу ИТА 2)

Дадлага, чиглүүлэх хөтөлбөр

- ✓ Шинээр ажилд орсон 27 ажилтанд чиглүүлэх 3 хоногийн сургалт, хөтөлбөрт хамруулж станцын үндсэн үйл ажиллагаа, компанид мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудын танилцуулгыг хийсэн байна.
- ✓ Шинээр ажилд орсон ажилтнуудад дадлага туршлагатай ажилтныг томилж багш шавийн гэрээ 9 ажилтантай гэрээ хийж, 4 ажилтанд багшийн урамшуулал олгож ажилласан байна.
- ✓ 2025 онд хамтын ажиллагааны хүрээнд гадны сургуулиудтай нийт 32 сурагцагчдыг удирдаж, дадлагыг хийлгэсэн байна.

Техникийн хичээл

Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ур чадварыг ахиулах зорилгоор хийгддэг ИТА нарын техникийн хичээлийг 14 ИТА, 18 цагийн хичээлийг 313 ажилтанд, Мэргэшсэн болон зөвлөх инженерүүдийн техникийн хичээлийг 4 ИТА, 6 цагийн хичээлийг 101 ажилтанд тус тус хуваарийн дагуу зохион байгуулж, хамруулсан байна.

ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ

2025 онд компанийн хэмжээнд Гүйцэтгэх захирлын баталсан болон тушаалаар баталгаажуулсан 5 дүрэм, 66 журам, нийт 71 дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна. Тайланд онд 1 дүрэм, 5 журамд нэмэлт өөрчлөлт оруулсан нийт 6 дүрэм, журам шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Шинэчлэгдсэн дүрэм, журмууд

№	Эрх зүйн актын нэр	Тайлбар
1	Өрх хий Хугацаа дууссан урхай зөвлөгөөн	Шинэчлэн найруулга хийсэн
2	Техникийн комисс ажиллуулах журам	Шинэчлэн найруулга хийсэн
3	Шалган нэвтрүүлэх постны журам	Шинэчлэн найруулга хийсэн.
4	Ахмадуудыг бүртгэж авах журам	Шинэчлэн найруулга хийсэн.
5	Компанийн дүрэм	Шинэчлэн найруулга хийсэн.
6	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам	Шинэчлэн найруулга хийсэн

Гэрээ, хэлцэлүүд

2025 онд компанийн хэмжээнд нийт 120 гэрээ байгуулагдсан байна. Үүнээс:

№	Гэрээний төрөл	Тоо
1	Хамтран ажиллах гэрээ	3
2	Бусад гэрээ	15
3	Хөлсөөр ажиллах гэрээ	2
4	Худалдах, худалдан авах гэрээ	60
5	Сургалтын гэрээ	6
6	Хэрэглэгчийн гэрээ	29
7	Түрээсийн гэрээ	5
8	Нийт	120

СОЁЛ, СПОРТ, ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ

2025 онд зохион байгуулсан урлаг, спорт, баяр ёслол, олон нийтийн арга хэмжээ

№	АРГА ХЭМЖЭЭ	БИЕЛЭЛТ
1	Нийт ажилтны хурал	2025 оны 02 сарын 26-ны өдөр гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү 2024 оны ажлын тайланг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, мэдээлэл хүргэв. Хурлын үеэр Монголын стандарт, чанарын хүрээлэн НҮТББ-ийн захирал Г.Гантөмөр, Мон майнинг сертифицикешин ХХК-ийн захирал Г.Баярхүү нар “ДЦС-2” ТӨХК-д ISO 45001:2018 Олон Улсын стандартын гэрчилгээг гардуулан өгөв.
2	Сар шинийн золголт	Могой жилийн Компанийн сар шинийн баярын нэгдсэн золголтыг 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хурлын зааланд зохион байгуулав.
3	Байгууллагын аварга шалгаруулах спортын 5 төрөл тэмцээн	Байгууллагын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд зохион байгуулав. Багийн дүнгээр “Зуухан цех”-ийн хамт олон шалгарч шилжин явах цомын эзэн болсон.
4	Ахмадын аварга шалгаруулах спортын тэмцээн	Байгууллагын ахмадын аварга шалгаруулах “Ширээний теннис”, “Дартс”-ын тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.
5	Туг мандуулах ёслол	Монгол Улсад Тулгар төр байгуулагдсаны 2234 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Ардын хувьсгалын 104 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг угтан Монгол Улсын төрийн далбааны өдрийг Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хамгаалалтын 7 дугаар салбартай хамтран “Туг мандуулах ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулав.
6	Эрчим хүчний ажилтны өдрийн баярын хурал	Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 103 жил, “ДЦС-2” ТӨХК-ийн 64 жил, Эрчим хүчний ажилтны өдрийг тохиолдуулан баярын хурлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав. Хурлын үеэр Алтан гадас-2, Хөдөлмөрийн хүндэт-1, Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдэг-8, Эрчим хүчний яамны "жуух бичиг"-8, 20, 25, 30 жил ажилласан 9 ажилтныг мөнгөн шагналаар, Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" алтан медаль-6, тус холбооны "Хөдөлмөрийн алдар" медаль-2 хүнийг тус тус шагнаж урамшуулав.
7	Ажил мэргэжлийн аварга шалгаруулах баярын хурал	Ажил мэргэжлийн аварга шалгаруулах баярын хурлыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав. Баярын хурлаар оны хөдөлмөрийн болон ажил мэргэжлийн аваргуудыг шалгаруулах, холбогдох шагнал урамшуулал, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, ХЭТРЭЛТ
ХЭМНЭЛТ

4.1. Нийгмийн асуудлын талаар

Хамтын гэрээнд заасан буцалтгүй тусламж, тэтгэмж, дэмжлэгийн судалгааг ажилтан, өндөр настан, групптэй хүмүүсээр ангилан сүүлийн 2 жилээр харьцуулан хүснэгтээр харуулав.

№	Тэтгэмжийн төрөл	2024 он				2025 он			
		Ажилтан		ӨНГХ		Ажилтан		ӨНГХ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Сувиллын хөнгөлөлт	11	1.500.000	27	1.930.000	5	820,000	16	1.150.000
2	Группэд гарсны нөхөн төлбөр	1	17.522.493	-	-	-	-	-	-
3	Нас барсан буюу таалал төгссөн тусламж /ар гэр/	6	31.680.000	8	25.344.000	7	44.220.000	2	4.514.400
4	Биеийн байдал, амжиргааны түвшин, Эмчилгээний тусламж	-	-	-	-	-	-	3	4.534.400
5	Өндөр насны тэтгэвэрт гарсан	11	624.272.000	-	-	10	749.887.600	-	-
6	Группээс өндөр настанд шилжсэн	-	-	3	45.408.000	-	-	2	53.856.000
7	Халаалтын улирлын хөнгөлөлт	291	34.950.000	210	21.000.000	280	33.400.000	215	17.000.000
8	Групптэй хүмүүст олгосон урамшуулал/хүндэтгэл	-	-	11	503,800.00	-	-	10	500.00
9	Өндөр настан групптэй хүмүүст олгосон урамшуулал /нэмэгдэл тэтгэвэр, ЭХТА нэмэгдэл,гарын бэлэг/	-	-	210	58.640.000	-	-	210	63.590.000
10	Орон сууцны дэмжлэг	15	166.666.665	-	-	16	155.000.000	-	-
11	Бусад тусламж, тэтгэмж, дэмжлэг /давагдашгүй хүчин зүйлд өртөж орон гэр нь эвдэрсэн/	1	1.000.000	-	-	1	2.000.000	--	-
Нийт		336	877.591.158	469	152.825.800	319	985.327.600	470	145.144.800
		1.030.416.958				1.130.472.400			

**2023-2025 оны урлаг, баяр ёслолын арга хэмжээний
зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл**

№	Зардлын төрөл	2023 он		2024 он		2025 он	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Урлаг, олон нийтийн арга хэмжээний зардал /мян.төг/	52,827	12,270	-	75,696	-	16,260
2	Баяр, ёслолын арга хэмжээний зардал /мян.төг/	82,539	95,871	-		-	
Нийт		135,366	108,141	-	75,696	-	16,260

**2025 оны үйл ажиллагааны бус орлогоос зохион байгуулсан
олон нийтийн арга хэмжээний зардал**

№	Зардлын төрөл	Гүйцэтгэл зардлын дүн /мян. төг/	Тайлбар
1	2	3	4
1	Спортын 5 төрөлт тэмцээн	11,060.0	Үйл ажиллагааны бус зардал
2	Сар шинийн золголт	3,200.0	
3	Компанийн ахмадын аварга шалгаруулах спортын тэмцээн	2,000.0	
Нийт		16,260.0	

ДҮГНЭЛТ

- ✓ Тайлант онд Хөдөлмөрийн тухай хууль, бусад хуулиуд, Хамтын хэлэлцээр, Хамтын гэрээ, Компанийн хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөн, хэрэгжилтийг хангаж Захиргаа удирдлагын хэлтсийн нийт албан хаагчид ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил, үүргээ амжилттай сайн биелүүлж ажиллалаа.
- ✓ Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам шинэчлэн батлагдсантай холбоотойгоор ирэх онд тухайн журмын хэрэгжилтийг хангаж ажиллах нь цаашдаа хүний нөөцийн төлөвлөлт, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй үр нөлөөтэй явуулахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.
- ✓ 2025 оны гүйцэтгэлээс харахад шинээр ажилд орсон болон ажлаас гарсан ажилтнуудын тоо өмнөх онуудаас харьцангуй буурч тогтворжсон харагдаж байгаа хэдий ч 2026 онд бид нөөц боловсон хүчийг бэлтгэх, ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллах шаардлагатай. Үүний тулд түлхүүр ажлын байрны залгамж халааг бэлтгэх сургалтыг системтэй болгох, их дээд сургууль, сургалт үйлдвэрийн төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, Дадлага, туршлагатай Инженер техникийн ажилтнууд, мэргэшсэн болон зөвлөх инженерүүдийн нөөц боломж, мэдлэг мэдээллийг ашиглан ажилтнуудыг ажлын байран дээр сургах, байгуулагадаа нутагшуулах ажлыг түлхүү зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.
- ✓ Хүний нөөцийн бодлогын хүрээнд болон өмнөх оны тайлан хурлын үүрэг чиглэлийн дагуу бид дагалдан ажилтанг дотооддоо мөрдөгдөж байгаа хэм хэмжээний хүрээнд шийдвэрлэх замаар жинхлэх хугацааг заагдсан хугацаанаас хэтрүүлэхгүй байхаар зохион байгуулан ажиллаж ирлээ. Цаашид дагалдан ажилтны мэдлэг чадварыг оновчтой байдлаар дээшлүүлэх, идэвхийг өрнүүлэх ажлыг тасралтгүй эрэлхийлж байх нь чухал юм.
- ✓ 2025 онд сургалтын төлөвлөгөө нь 79.9 сая төгрөг, давхардсан тоогоор 1225 ажилтныг сургалтад хамруулахаас гүйцэтгэл нь 57.5 сая төгрөг, давхардсан тоогоор 1081 ажилтныг сургалтад хамруулсан. Сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 72,0%-тай байна. Дээрх төлөвлөгөөний гүйцэтгэлд ЭХИС-ийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулагдаагүй ба нийтийг хамарсан сургалтуудаас “Байгууллагын соёл”-ын сургалтыг удирдлагын шийдвэрээр хойшлуулсан нь сургалтын гүйцэтгэлд нөлөөлж байна.

- ✓ Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөний дагуу 2025 онд байгууллагын Данс№4 /байнга, түр/, Данс№5 /байнга, түр/, 70 жил хадгалах баримт, устгах баримтуудын жагсаалтыг баталгаажуулах, Данс №4-ийг шилжүүлж өгөх ажлаас гадна Компанийн архивын дүрэм, Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг шинээр батлуулсан байна. Мөн архивын баримтын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх хүрээнд түүхчилсэн лавлах, танилцуулга, заагуур, заагчийг бэлтгэн, цахим хэлбэрт шилжүүлэх ажлуудыг тус тус гүйцэтгэв.
- ✓ Архивын улсын үзлэгшалгалтад Улсын үзлэгийн төв комиссын даргын баталсан хуваарь, дүгнэх аргачлалын дагуу 2025 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд компанийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр хамрагдав. Уг үзлэг шалгалтад хамрагдаж 90% буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.
- ✓ Эрүүл мэндийн үзлэг шинжилгээг “Итгэл” эрүүл мэндийн төвтөй 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, 256 ажилтан албан хаагч хамрагдлаа. Үүнээс шаардлагатай ажилтан албан хаагчдын харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүдрүү явуулж шаардлагатай эмчилгээг хийлгүүлсэн байна.
- ✓ Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хамгаалалтын 7-р салбартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд, дагаж мөрдөх хоёр талын хамтран баталгаажуулсан журмын дагуу хамтран ажиллаж аливаа гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан.
- ✓ Компанийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах чиг үүргийг мөн хэрэгжүүлж аливаа зөрчил дутагдалгүйгээр зохион байгуулж ажиллалаа.
- ✓ 2025 онд Сар шинийн золголт, Байгууллагын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээн, Ахмадуудын дундах спортын тэмцээн, Туг мандуулах ёслол, Эрчим хүчний ажилтны өдрийн болон Ажил мэргэжлийн аварга шалгаруулах баярын хурлыг тус тус зохион байгуулсан байна.

ИРЭХ ОНД ДЭВШҮҮЛЖ БУЙ ЗОРИЛТ, САНАЛ САНААЧЛАГА

Д/д	Зорилт	Зорилтод хүрэх хугацаа
1	Нийт ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлбэрийг дүрэм журамд нийцүүлэн бүрдүүлж жагсаалт үйлдэн баталгаажуулах;	Жилдээ
2	Компанийн бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны нэршил тодорхойлолтын шинэчлэлттэй холбоотойгоор нийт ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний хугацаа болон нэмэлт өөрчлөлтийг тусган баталгаажуулах;	Жилдээ
3	Хэлтсийн албан хаагч тус бүр өөрсдийн гүйцэтгэж буй ажил мэргэжлийн холбоотой сургалтад хамрагдаж, өөрсдийгөө хөгжүүлэх;	Жилдээ
4	Компанийн хэмжээнд явагдаж буй сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, чанаржуулах тал дээр анхаарал хандуулан ажиллана. - Сургалтын журамтай холбуулан бичиг баримтын шинэчлэлийг ажлыг хийж гүйцэтгэх /Дагалдан суралцах хөтөлбөр, шалгалтын протоколыг шинэчлэх/; - ИТА-нууд болон мэргэшсэн, зөвлөх инженерийн сургалтад техникийн хичээлийг хуваарийн дагуу явуулж хэвшүүлэх; - ИТА өдөрлөг зохион байгуулах Компанийн нийт ажилтнуудад “Байгууллагын соёл”-д нөлөөлөх сургалт зохион байгуулах /харилцаа хандлага, хувь хүний хөгжлийн чиглэлээр/;	Жилдээ
5	Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, Хөдөлмөрийн дотоод журмыг видео танилцуулга хэлбэрээр хийх;	II улирал
6	Шинэ сургалтын кабинетыг тохижуулах;	Жилдээ
7	2026 онд холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт орсон тухайд нь компанийн дотоод хэм хэмжээ эрх зүйн актыг цаг тухай бүрт нь шинэчлэн найруулах ба Шинэчлэгдсэн дүрэм, журмуудыг ажилтнуудад сурталчлах;	Жилдээ
8	Байгууллагатай холбоотой шүүхийн шатанд хянагдаж байгаа нэхэмжлэлүүдийг шийдвэрлүүлэх;	Жилдээ
9	Албан хэрэг хөтлөлтийг монгол бичигтэй уялдуулж ажиллах, компанийн ИТА-нууд болон захиргааны ажилчидад хэвшүүлэх	Жилдээ

10	Архивын ерөнхий газраас ирсэн үзлэг шалгалтын дүгнэлтийн дагуу төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллах;	жилдээ
11	Ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулж, үзлэгийн мөрөөр зохион байгуулалттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн бусад байгууллагуудтай хамтран ажилтнуудыг цаг үетэй холбоотой эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах;	Жилдээ
12	Ажилтнуудын биеийн идэвхийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор “Бидний алхам – Бидний эрүүл мэнд” явган аялал зохион байгуулах (сард 1 удаа);	Жилдээ
13	Баяр ёслол, олон нийт, үйл ажиллагааг төсөвт төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;	Жилдээ